

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 2016 онд Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг нийгмийн тухайн жилийн зорилтод тусгагдсан соёл урлагийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Соёл урлагийг хөгжүүлэхээр дэвшиүүлсэн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлого, чиглэлийг тогтоож, эрх зүйн орчин бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг тасралтгүй хүргэж Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 2016 онд Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, тухайн жилд төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний үндсэн дээр 28 арга хэмжээ, тусгай 25 арга хэмжээ болон нийт 48 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж ажилласнаас жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй хэрэгжсэн.

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

Дээд газраас ирсэн тогтоол, захирамж шийдвэр нийт 30, бүртгэлжүүлэн, хэрэгжүүлж хяналтад авч албан хаагчид болон холбогдох албан тушаалтанд шилжүүлж, биелэлтийг улирал тутам тайлагнаж ажилласан.

Үүнд:

- ЗГ-ын тогтоол-1
- НИТХ-ын тогтоол 2
- НЗД-ын захирамж-25
- Нийслэлийн Засаг даргын албан даалгавар -2

Нийслэлийн Соёл, урлагийн газраас 2016 онд төлөвлөж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жилийн ажлын тайлант Нийслэлийн Засаг даргын 2013 оны 1146 дугаар захирамжийн дагуу болон Соёл, урлагийн ажлын үндсэн чиг үүргүүдийн хүрээнд боловсруулан хугацаанд нь тайлагнаж ажилласан. Тус газар нь 2016 оны жилийн эцсийн байдлаар холбогдох дээд шатны байгууллагуудад тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үүнд:

➤ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийг програмд оруулан илгээж, улирал бүр цаасан хэлбэрээр НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн,

➤ Тус газрын 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт,

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн сургалт сурталчилгаа хууль тогтоомжийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан,
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын тайлан,
- Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээ,
- Төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлт,
- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан,
- Удирдлагууд иргэдтэй хийсэн уулзалтын тайлан,
- Үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийн мэдээ,
- БСШУСЯ-ны сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Нийслэлийн Засаг даргын хооронд 2016 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийн тайлан мэдээг нэгтгэж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт:

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 2016 онд Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилт, тухайн жилд төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний үндсэн дээр 23 арга хэмжээ, тусгай 25 арга хэмжээ болон нийт 48 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж ажилласнаас жилийн эцсийн байдлаар 100 %-ийн биелэлтэй хэрэгжүүлсэн.

Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг байгууллагын албан хаагчдад тухай бүр танилцуулж, биелэлтийг гарган сар бүр цаасан болон цахимаар хүргүүлж ажилласан.

Улирал бүр үр дүнгийн гэрээний биелэлтийн талаархи тайланг Нийслэлийн Засаг даргын салбар хариуцсан орлогч даргад тайлагнаж ажиллалаа.

Боловсрол Соёл, Шинжлэх ухааны сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд 2016 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлт

Боловсрол соёл, шинжлэх ухааны салбарын стратегийн ач холбогдол, тоо хэмжээ, чанар, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлох, үр дүнг үнэлж, дүгнэх замаар нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.

БСШУСЯ-ны сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Нийслэлийн Засаг даргын хооронд 2016 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний зургаадугаар хавсралтын дагуу хэрэгжилтийг гарган НЭДТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт соёл урлагийн чиглэлээр тусгагдсан доорх ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

“Монгол цуур” үндэсний хөтөлбөрийн хүрээнд:

Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын дэргэдэх “Их Монгол” хамтлаг болон “Дэлхий” хамтлагийн уран бүтээлүүдэд хөгжимчин Б.Мягмарцэрэн цуур хөгжмөөр хөг нэмж оролцоноос гадна энэ онд цуурын 6 татлагыг сурсан бөгөөд 6 ширхэг цуур хөгжмийг урласан байна. Тус чуулгын уран бүтээлчид Бүгд Найрамдах Солонгос улсад болсон олон улсын язгуур урлагийн наадамд амжилттай оролцож Монгол цуур хөгжмийг олон улсад сурталчлан таниулсан.

Боловсрол, Соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төвтэй хамтран цуур хөгжмийн уламжлал, цуурдах урлагийг хадгалж хамгаалах, хөгжүүлэх, өвлөн уламжлуулах, судлах, сурталчлах, цуур, цуур төст хөгжмийг хүлээн зөвшөөрч түгээн дэлгэрүүлэх, харилцаа холбоог судлах, хөгжүүлэх зорилгоор “Монгол цуур” олон улсын симпозиум, наадмыг 2016 оны 06 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан. Мөн Соёлын өвийн төвөөс цуур хөгжмийн уламжлалт урлагийг хадгалж хамгаалах, хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэх, судлах, сурталчлах, цуурчид, цуурын уламжлалт урлагийг дэмжих, цуур, цуур төст хөгжмийн уламжлалыг олон улсын түвшинд харилцан хүлээн зөвшөөрч түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Цуур” олон улсын анхдугаар симпозиум-наадмыг 2016 оны 6 дугаар сарын 4-наас 5-ны хооронд зохион байгуулсан бөгөөд уг үйл ажиллагаанд Нийслэлийн Соёл, урлагийн газрын холбогдох мэргэжилтэн хамрагдсан.

“Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд:

Д.Нацгдоржийн нэрэмжит Улаанбатаар хотын төв номын сан үүсгэн байгуулагдсаны 35 жилийн ойг утган “Д.Нацгдоржийн шагналт зохиолчдын нэрэмжит уншлага” үйл ажиллагааг сар бүр зохион байгуулж энэ ажлын хүрээнд:

- Д.Нацгдоржийн нэрэмжит Хүүхдийн зохиолчдын уран бүтээлийг 14 хоногийн хугацаанд сурталчлан уншуулах,
- Дээрх уншлагын хүрээнд хамгийн олон ном уншсан уншигчид 1-2 ном гэрээр үнэгүй авах эрхийн бичиг “Урамшуулалтай уншлагын купон” олгох ажлыг зохион байгуулан ажилласан,
- “Бэлэгтэй уншлага” - хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж уншсан номын тэмдэглэл хөтлөн, уншсан номтойгоо холбогдуулж олон бүтээлч ажил хийсэн хүүхдүүдийг шалгаруулж шагнал урамшуулах өгөх,
- “Гэр бүлийн уншлага” - картын системд 24 өрхийн 64 иргэн хамрагдav. Хөтөлбөрийн танхимд 7 хоногийн 4 дэх өдөр бүр 4-8 насны хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ ирж тоглоомын цагаар хөдөлгөөнт электрон лего угсарч уралддаг. Реппер Цэцэнбилэгийн тохижуулсан “Гэр бүлийн уншлага” - ын танхимд 4-6 насны хүүхдүүдэд 7 хоногийн хагас сайн өдөр Гэр бүлийн уншлага явагддаг.

Зуны уншлагыг тусгай төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу:

- СХД-ийн Орбитын 22 дугаар хороон дээр очиж “Уланбаатарчууд уншиж байна” ажлын хүрээнд “Зуны зугаатай уншлага” зохион байгуулсан. Нийт 40 хүн оролцсон. Уншигчдад дэлхийн шилдэг зохиолуудаар номын үзэсгэлэн гаргасан,
- “Зугаатай уншлага” ЕБС-ийн 1,2 дугаар ангийн 139 сурагчдад бичиг үсэг сурч буй хүүхдүүдэд ном унших сонирхол төрүүлэх, чадвар эзэмшүүлэх, ном унших төрөл бүрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан,
- ЕБС-ийн сурагч, оюутан залуучуудын гадаад хэлний түвшинг нэмэгдүүлэх, тухайн гадаад хэлний орчинг бүрдүүлэх зорилгоор “Залуус хөгжлийн төв”-

тэй хамтарч сард 2 удаа кино хичээл зохион явуулж мөн нийт 470 уншигч хэрэглэгчдэд киног үзүүлсэн,

- “Тоглоомын өдөр” хөтөлбөр нь нийт 13 удаа явагдаж 61 хүүхэд хамрагдсан. Кино үдэш хөтөлбөр нь 26 удаа 598 оролцогч хамрагдсан. 4Н хүүхдийн хөтөлбөр нийт 16 удаа явагдаж 403 хүүхэд оролцсон,
- Хүүхдийн уншлагын танхимд “Үлгэрийн цаг”, “Чанга уншлага”-ыг зохион явуулдаг ба О.Сундуй “Үнэг” өгүүллэг, “Сургамжит өгүүллэг-1” номоор, “Эвтэй 4 амьтан”, “Муур багш”, “Ухаант туулай”, “Муур багш”, “Өөрөөрөө байх шиг сайхан зүйл үгүй” үлгэрээр, “Хөгжилтэй Өүжин дэлдэн хоёр”, Роберт Манчын “Ямар нэгэн гоё юм” зохиолоор, “Үлгэрийн цаг”, “Сургамжит өгүүллэг” зэрэг чанга уншлагыг монгол, англи хэлээр нийт 70 гаруй удаа зохион байгуулж нийт 366 оролцогч хамрагдсан,

Фондын ном бусад материалыг сурталчлах зорилгоор түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэн гаргах, байнгын үзэсгэлэнг солих, Харааны бэрхшээлтэй иргэд олон нийтэд “Хүртээмжтэй технологийн уулзалт” сургалтыг уншлагын танхим болон бусад харгаагүйчүүдийн байгууллагуудад очиж зохион байгуулж 10 орчим хүмүүсд програм хангамжийн болон компьютерийн үйлчилгээ үзүүлсэн байна. MXYX-ны дэрэгдэх мэрэгжил сургалтын төвийн 6 компьютерт монгол хэлний ярьdag програм хангамж суулгасан.

“Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээ”-ний албан ёсны facebook хуудсыг www.facebook.com/bdalibrary-г нээн хөтөлж, үйлчилгээний танилцуулгыг байршуулсан байна. Боловсрол соёл шинжлэх ухааны яамны 50 сая төгрөгийн санхүүжилтээр харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Daisy talking book center” буюу Дэйзи студид бүтээгдсэн хүртээмжтэй хэлбэрийн 100 ширхэг цахим номыг CD дээр буулгаж, нэг бүрчилсэн бүртгэлд авч, каталогжуулах төслийг хэрэгжүүлж байна.

“Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах хоёр дахь шатны хөтөлбөрийн хүрээнд:

16 дэсийн 16 ширхэг баримт бичиг, бэлэглэлээр ирсэн 2 дэсийн 2 ширхэг эд өлгийн зүйлийг музейн захирлын 2016 оны А/11 дүгээр тушаалаар музейн үзмэрийн ерөнхий бүртгэлд бүртгэн авч, музейн сан хөмрөгийг 18 дэсийн 18 ширхэг үзмэрээр баяжуулав.

Улаанбаатар хотод Санкт Петербургийн соёлын өдрүүдээр “Санкт-Петербургийн зүрхнээс Азийн зүрхэнд” сэдэвт үзэсгэлэнд дэлгэгдсэн Рерихийн 1926-1927 онд Монголд авсан 57 гэрэл зураг, болон үзэсгэлэнгийн тайлбарт хуйлдаг 9 самбарыг Рерихийн Шамбала музейн зөвшөөрлөөр, сургалт, сурталчилгаанд ашиглах зориулалтаар музейн бүртгэл мэдээллийн санд бүртгэн авч, баяжилт хийв.

RCH программ дээр угсаатан зүйн 58 дэсийн 110 үзмэрийн нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Үндсэн сан хөмрөгийг үзмэрийг каталогжуулах (хувийн хэрэг) ажлыг хуваарийн дагуу хийж, баримт бичгийн төрлийн 99 дэсийн 133 ширхэг, Зоос мөнгөн тэмдэгтийн 33 дэсийн 224 ширхэг, Зураг урлалын төрлийн 122 дэсийн 131 ширхэг, Гэрэл зургийн төрлийн 56 дэсийн 235 ширхэг, нийт 310 дэсийн 723 ширхэг үзмэрийг каталогжуулаад байна.

98 дэсийн 325 ширхэг үзмэрийг шүлтгүй цаасаар хамгаалалтын уут хийж хадгалалтын байдлыг сайжруулсан.

Яаралтай сэргээн засварлах шаардлагатай 10 дэсийн 10 үзмэрийг Соёлын өвийн төвд сэргээн засварлуулахаар явуулснаас 1 дэсийн 1 ширхэг үзмэр 2016 онд сэргээн засварлагдаж ирсэн байна.

Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтод тусгагдсан ажлын хүрээнд:
Мансууруулах бодисын хорт нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиаглэлээр хийсэн ажил:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг нийгмийн 2016 оны зорилтод тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар оны эхэнд харьяа байгууллагууд, дүүргүүдийн соёлын орднуудад чиглэл өгч ажиллаа. Үүний дагуу дараах ажлуудыг дүүрэг харьяа байгууллагуудаас зохион байгуулж ажилласан байна.

Баянгол дүүрэг:

Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран харьяа дүүргийн Их Монгол ДС, ОУБДС, Энх-Орчлон ДС-н оюутнуудад" Тамхины хэрэглээ түүний хор уршиг", "Донтолт түүнээс урьдчилан сэргийлье" сэдвүүдээр сургалт зохион байгуулж нийт 3280 оюутныг хамрууллаа. Өсвөр үеийхэнд сэтгэцийн эрүүл мэндийн талаар ойлголттой болгох зорилгоор "Өсвөр насын сэтгэцийн эрүүл мэнд", "Сэтгэлгээгээ өөрчлөө" сэдэвт сургалтуудыг ерөнхий боловсролын 93, 47, 96-р сургуулийн ахлах анги, мөн Албан бус насан туршийн боловсролын нийт 380 сурагчдад зохион байгууллаа. Мөн Баянгол дүүргийн Хүүхэд хөгжлийн төвөөс "Өсвөр үе, охид хөвгүүдийн эрүүл мэнд" сэдэвт сургалтын төлөвлөгөө батлуулан ЕБС-иудын 6,7,8 дугаар ангийн сурагчдад сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

Тус сургалтанд " Өсвөр насын охид, хөвгүүдийн сэтгэл зүй, бие махбодид гарах онцлог", "Архи, тамхины хор холбогдол", "Зөв хооллолтын ач холбогдол" сэдвээр Баянгол дүүргийн 19, 20, 51, 38, 73, 13, 47, 113,78, 28,40,Эрдмийн өргөө ЦС, Монгени, Сэтгэмж, Оюуны ундраа ЦС зэрэг нийт 15 ЕБС-уудын 7,8 дугаар ангийн 2726 сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгож, мансууруулах бодисын хор нөлөөг таниулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна.

Сүхбаатар дүүрэг:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дүүргийн 9-12 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг, байнга архидан согтуурч, орчиндоо түгшүүр төрүүлдэг иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаар сэрэмжлүүлэг, мэдээлэл, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зорилгоор дүүргийн ЗДТГ, Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих төвтэй хамтран 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Гэрэлт ирээдүй" сэдэвт уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Баянзүрх дүүрэг

Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс ерөнхий боловсролын 8 сургуулийн 680 багш, сурагчид болон Газарчин дээд сургуулийн 62 оюутанд тамхины хор хөнөөл, дам тамхидалтын хор уршиг, хорт зуршлын талаар сургалтыг зохион байгуулсан.

ӨЭМТ-ийн вэб сайтад "Архины биед үзүүлэх нөлөө" сэдвээр мэдээ байршуулсан.

Мэдээлэл сурталчилгааг илүү хүртээмжтэй хүргэхийн тулд БЗДЭМТ-ийн болон 28-н хорооны ӨЭМТ-ийн цахим хуудсанд “Тамхи таны эрүүл мэндэд”, “Тамхинаас гарах аргууд”, “Тамхины хор уршиг”, “Дам тамхидалт”, “Тамхичин хүний биед гарах өөрчлөлтүүд” зэрэг сурталчилгаа байршуулж, орон сууцны хороолол болон ӨЭМТ-ийн мэдээллийн самбарт тамхины хор уршгийн талаар санамж материал байршуулан сурталчилгаа хийсэн.

БЗД-ийн 28-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-дад Тамхины хууль бус худалдааг зогсоо ё сэдэвт аяны хүрээнд 2016 оны 05 дугаар сарын 01 –ний өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийн хооронд харьяа хорооны хэсгийн байцаагчтай хамтран харьяа хорооны 8 нэрийн 58 дэлгүүр, 15 пабын үйл ажиллагаанд хяналт хийлээ. Хяналтаар 21 дэлгүүр тамхи ширхэглэн зарж байсан, 13 дэлгүүр Тамхины тухай хуулийн сургууль, цэцэрлэгийн ойр орчим 500м газарт тамхи худалдаалахгүй гэсэн хуулийн заалтыг зөрчсөн нь илэрсэн байна.

Аяны хүрээнд БЗДЭМТ салбар 3 амбулатори 28 ӨЭМТ-үүд дүүргийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг төрийн болон ТББ, ЕБС, цэцэрлэгүүдтэй хамтран дам тамхидалт, тамхинд донтох өвчний чиглэлээр 12 төрлийн 124 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 2410 гаруй хүнийг хамруулж тамхины хор уршгийн чиглэлээр сургалт сурталчилгаа явуулсан байна.

Дүүргийн соёлын ордон Архигүй, тамхигүй-Монголын төлөө хамтдаа” мансуурлаас сэргийлцгээ сургалт өдөрлөгийг Кино урлагийн дээд сургуулийн оюутнуудын дунд 2015-03-21 ны өдөр зохион байгуулсан байна. Өдөрлөгийн үеэр дэлгэцийн материалыаар бэлдсэн 20 минутын сээрэмжлүүлэг бүхий зурагт тайлбартай ухуулга аман яриаг 3D орчин үеийн кино дэлгэцийн проекторыг ашиглан хүргэсэн байна.

Дээрх байдлаар дүүргүүд харьяа байгууллагуудаас давхардсан тоогоор 600 гаруй гаруй сургалт, сурталчилгаа танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж 85200 гаруй хүүхэд запуусийг хамруулан ажилласан.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрийн хүрээнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 197 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2008 оны 357 дугаар захирамжаар батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/529 дүгээр захирамжаар хийгдсэн улсын үзлэг, тооллогод хамрагдсан дурсгалуудаас шинээр оруулах, хасах, хамгаалалтын зэрэглэл өөрчлөх дурсгалын саналыг авахаар дүүрэг, холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2007 оны 197 дугаар тогтоол, Засаг даргын 2008 оны 357 дугаар захирамжийн хавсралтуудыг шинэчлэн хариуцагч байгууллагуудтай хадгалалт, хамгаалалтын гэрээг шинэчлэхээр ажиллаж байна.

Соёлын салбарт Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрүүдийг Нийслэлд хэрэгжүүлэх чиглэлээр:

Соёлын салбарт Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрүүдийг нийслэлд хэрэгжүүлж ажиллалаа. Нийслэлийн Соёл, урлагийн салбарт “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” үндэсний хөтөлбөр, “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”, “Монгол цуур” хөтөлбөр, “Монгол тууль” хөтөлбөр үр дүнтэй, амжилттай хэрэгжиж байна.

“Хууртай мөнхрах аялгуу” уртын дуучдын уралдаан:

Нийслэлийн Соёл, урлагийн газар, Налайх дүүргийн Соёл, урлагийн ордон хамтран жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Хууртай мөнхрөх аялгуу-

2016” уралдаан нь уртын дуучин П.Долгорын нэрэмжит болж өргөжин XI дэх жилдээ 2016 оны 12 дцгаар сарын 09-ний өдөр Налайх дүүргийн Сочлын ордонд амжилттай зохион байгуулаглаа. Уралдаанд нийтдээ 80 уртын дууч, 5 морин хуурч, 1 лимбэчин оролцсон бөгөөд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Налайх, Багануур, Хан-Уул, Сонгинохайрхан, Багахангай, Баянгол дүүргүүдээс ирж 3 насны ангилалд өрсөлдсөн. Уралдааны шүүгчээр СУИС-н багш, Уртын дуу судлаач, МУСТА М.Дорждагва, Ахлах багш М.Алтанбат, Чингэлтай дүүргийн Соёлын төвийн арга зүйч, МУСТА Д.Цогтдэлгэр нар ажиллалаа.

Монгол ардын “Бий биелгээ-2016” долдугаар уралдаан:

Монгол бүжгийн угсаатны уламжлал, биелгээний ахуйн соёл, өвөрмөц төрх, аж амьдралын онцлогийг өсвөр үеийнхэнд өвлүүлэн үлдээх зорилгоор Нийслэлийн 9 дүүрэг болон зүүн бүсийн аймгуудын ЕБС-ийн сурагчдын дунд тус уралдааныг зарласан. 2016 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Налайх дүүргийн Соёл, урлагийн ордонд 3 насны ангиллаар гоцлол бүжиг, хамтлаг бүжиг, тайзны тавилтат бүжиг гэсэн 3 төрлөөр зохион байгуулсан.

Уралдааны шүүгчээр СУИС-н бүжгийн урлагийн ахлах багш, докторант, бий биелгээ судлаач, МУСТА М.Мөнгөнцэцэг, СУИС-н бүжгийн урлагийн сургуулийн ахлах багш С.Эрдэнэхорлоо, Соёл, урлагийн ордны дарга, МУСТА С.Баасанхүү нар ажилласан.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тус байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэгт, байгууллагын үндсэн үйл ажллагаатай холбогдол бүхий 14 заалт байдаг бөгөөд хэрэгжилтийг заалт тус бүрээр гарган нэгтгэн дүгнэлээ. Хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Байгууллагын болон ажилтнуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч даргаар байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагааны чадавхи болон ажилтнуудын үр чадвар мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр :

Нийслэлийн соёл, урлагийн газар түүний харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчид, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын Концертын танхимд нийслэлийн хэмжээнд зохион байгуулж буй соёл, урлагийн арга хэмжээнүүдийн зохион байгуулалтын талаар чиглэл өгөх, салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 5 сэдвээр мэргэжлийн багш нарыг урьж сургалт зохион байгууллаа. Сургалтад харьяа соёлын байгууллагуудын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэн, нягтлан бодогч, менежер, зохион байгуулагч, дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 60 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Бүгд Найрамдах Солонгос улсын “Хотын захирагч нарын холбоо”-ноос 16 дахь жилдээ зохион байгуулж буй “К2Н” буюу “Солонгосын зүрхнээс зүрхэнд”

сургалтын хөтөлбөрт Нийслэлийн Улаанбаатар чуулгын менежер Х.Болорбатыг 6 сарын хугацаатай сургалтад хамрууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Тус газар нь төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гаргасан хууль тогтоомж, стандарт, дүрэм зааврыг байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагад хандаж ирүүлсэн бүх төрлийн албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем болох EDoc.ub.gov.mn-д бүртгэж шийдвэрлэж ажиллах, архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, баримт бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн програм ашиглалтын сургалтыг зохион байгуулсан. Байгууллагын үйл ажиллагаанд архив, албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn програм нэвтрүүлж эхэлснээс хойш ашиглаж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Байгууллагад ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, хугацаатай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, дээд газар болон харьяа байгууллагуудад явуулсан бичгийн эргэлтэд хяналт тавьж явуулсан бичгийн мэдээг сар бүр гаргаж ажилласан.

Нийслэлийн Соёл, урлагийн салбарын харьяа байгууллагуудыг хамруулан 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Нэгдсэн сургалт зохион байгуулж сургалтад мэргэжлийн багш нар хүрэлцэн ирж мөн Нийслэлийн Архивын газрын дарга С.Гаваа “Архив албан хэрэг хөтлөлтийн хууль, тогтоомж, стандартын дагуу баримт бичиг боловсруулах” талаар сургалт зохион байгуулж, 12 дугаар сарын 09-нөөс 15-ыг хүртэл харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах ажлын дагуу Архив, бичиг хэргийн ажилтнуудын албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn програм ашиглалт, хэрэгжүүлж ажиллаж байгаа тал дээр хяналт тавьж шалгасан.

Энэхүү хяналт, шалгалтаар тус газрын харьяа 6 соёлын ордон, 1 соёлын төв, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Улаанбаатар хотын музей, Соёлын төв өргөө, Улаанбаатар чуулга зэрэг байгууллагууд баримт бичгийг нэгдсэн урсгалд шилжүүлж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Мөн албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn програмын талаар зөвлөгөө өгч ажилласан.

Байгууллагын ажилчдад танхимиын бус хэлбэрээр дотоод сүлжээ, вэб сайт, цахим гарын авлагаар хангаж ажилласан. Байгууллагад жилийн эцсийн байдлаар /Edoc.ub.gov.mn/ ирсэн бичиг нийт 212, хариутай бичиг 71, хариугүй 141, хугацаандаа шийдвэрлэсэн 178, шийдвэрлэлтийн байдал 91,88 %, явуулсан бичиг нийт 426 байна.

Урлагийн хэлтэст ирсэн бичиг 50, хариугүй 33, хариутай 17, хугацаандаа шийдвэрлэсэн 38, шийдвэрлэлтийн хувь 98,49 % байна.

Соёлын хэлтэс ирсэн бичиг 95, хариугүй 70, хариутай 25, хугацаандаа шийдвэрлэсэн 82, шийдвэрлэлтийн хувь 91 % байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Архивын газраас 2016 оны 12 дугаар сарын 04-ний өдөр “Нийслэлийн хэмжээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх нь” сэдэвт нэгдсэн сургалтад хамрагдсан.

Архивын тухай хууль тогтоомж, албан хэрэг хөтлөлтийн зааврыг дагаж мөрдөх, Захирамжийн биелэлтийг хангаж ажиллах, Бүтэц орон тоо өөрчлөгдсөн бол байгууллагын ХХНЖ-ийг шинэчлэх, ангилах, ББНШАЗК-ыг онлайнаар шийдвэрлэж байгаа, Сургалт арга зүй, онлайн тест хичээлийг ашиглах, Edoc.ub.gov.mn албан хэрэг хөтлөлтийн програмыг ашиглаж хэвших, хяналт тавих, Ажил хүлээлцэх акт А/933 дугаар захирамжийн дагуу үйлдэх, Байгууллагын архивт баримт бичгийг ХХНЖ-ийн дагуу хүлээн авах, Дуу авиа, дүрс бичлэгийн баримтыг жил бүр архивт хүлээлгэн өгөх, Шинээр үүссэн баримтад акт үйлдэх / Нийслэлийн архивт

хүргүүлэх/, Мэргэшүүлэх сургалтад хамрагдах, Харьяа байгууллагууддаа Edoc.ub.gov.mn албан хэрэг хөтлөлтийн програмыг ашиглаж хэвших талаархи сургалтад хамрагдсан.

Архивын чиглэлээр:

Архивын чиглэлээр тус газрын мэргэжилтнүүдээс байгууллагын архивт баримт хүлээлгэж өгөх ажлын хуваарийн дагуу баримтыг эмхлэн цэгцлэн хүлээн авч дуусч байнга, түр, 70 жилийн хадгаламжийн нэгжийн дагуу агуулга, ач холбогдолоор нь ангилан төрөлжүүлж, хадгалах хугацааг тогтоон, техник боловсруулалт хийн тус бүр баримт хүлээн авсан бүртгэл үйлдэж ХХНЖ-ын дагуу авч ажиллалаа.

Архивт хадгалагдах байнга 50, түр 54, 70 жилийн 2 нийт 106 баримтад данс бүртгэл буюу хадгаламжийн нэгжийн бүртгэлийг үйлдэж дууссан. Байгууллагын нийт ажилтан албан хаагчдад 2016 оны 02 дугаар сард архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн програм нэвтрүүлэх чиглэлээр Нийслэлийн Архивын газраас мэдээлэл технологийн мэргэжилтэн ирж сургалт зохион байгуулсан. Мөн мэргэжилтнүүдийн цахим гарын үсгийн баталгаажуулалт хийн, программ суулгалт хийсэн.

Төрийн архивын нэгдсэн системд:

1. Албан хэрэг хөтлөлтийн
2. Байгууллагын архивын
3. Төрийн архивын /Онлайн лавлагааны систем/ гэсэн ашиглалтын системтэйгээр байгууллагын үйл ажиллагаандaa нэвтрүүлж ашиглаж байна.

Мөн албан хаагчдын 2015 оны ажлын файлуудыг DVD буулгаж цахим баримт бүрдүүлсэн. Lavalgaa.ub.gov.mn цахим сайтад байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн тоон тайланг хугацаанд нь орууллаа.

Тус газрын архивын үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Архивын сан хөмрөтт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам батлах тухай” А/177 захирамжийн хэрэгжилтийн дагуу цахим нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт хийх ажлыг Нийслэлийн Архивын газраас шинэчлэн гаргасан байгууллагын Archive doc програмд оруулсан захирамжлалын баримт бичгийг “Цахим нягтлан шалгалт” хийсэн ажлын мэдээг албан бичгээр хүргүүлсэн.

2015 оны захирамжлалын баримтыг агууллагыг шивж, цахим файл хавсарган байгууллагын архивын хэсэгт оруулан хадгалсан. 1994-2014 оын 20 жилийн баримтыг Archive e Doc програмд файлуудыг оруулан, агуулга болон хавсралтуудын бүрдэлд нягтлан шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын архиваас түр олгосон баримт нийт 10 хадгаламжийн нэгж, байгууллага дотооддоо 15, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт 1 хадгаламжийн нэгж акт үйлдэн ашиглуулсан байна.

Архивын өрөөний чийг дулааныг тогтмол хэмжиж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэн, бүртгэлийн дэвтэрт бүртгэн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын стандартыг хангаж ажилласан. Байгууллагын архивын үйл ажиллагааны тайланг 2016 оны жилийн эцсийн байдлаар гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн. Мөн байгууллагын архивт хадгалагдаж буй баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг гаргаж Үндэсний архивын газарт хүргүүллээ.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

Бүгд найрамдах солонгос улсын сөүл хотод зохион байгуулсагдсан “Seoul friendship fair 2016” наадам:

Нийслэлийн Засаг даргын А/326 дугаар захирамжийн дагуу 2016 оны 05 дугаар сарын 05-наас 09-ний өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан “Seoul Friendship Fair 2016” Олон улсын ардын урлагийн наадамд Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчид зэрэг 20 хүний бүрэлдэхүүнтэй урлагийн баг амжилттай оролцсон.



“Seoul Friendship Fair 2016” олон улсын наадмын урлагийн тогтолт 2016 оны 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд зохиогдож Нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчид үзэгч олноос өндөр үнэлгээг авч үзэгчдийн саналаар




тэргүүлэн, Улаанбаатар хотыг сурталчилан ажиллалаа. Урлагийн тогтолтын найруулагчаар Нийслэлийн Улаанбаатар чуулгын найруулагч П.Урнаа ажилласан бөгөөд урьдчилан бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу тогтолтыг амжилттай зохион байгууллаа.

Санкт-Петербургын хотын соёлын өдрийн

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Санкт-Петербург хотын захиргаатай хамtran Улаанбаатар хотод “Санкт-Петербург хотын соёлын өдрийд”-ийг 2016 оны 04 дүгээр сарын 27-ноос 29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаа нь Санкт-Петербург болон Улаанбаатар хотын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Санкт-Петербург хотын соёлыг сурталчлах, Рерихийн гэр бүлийн музейн хүрээлэнгээс “Санкт-Петербургийн зүрхнээс Азийн зүрхэнд” хэмээх нэртэй Монголын түүх, ахуй амьдралтай холбоотой үзэсгэлэнг гаргасан.



Мөн 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Санкт-Петербург Опера” хөгжмийн театр, УДБЭТ-тай хамtran “Найрамдлын цуурай” концертыг УДБЭТ-ын тайзнаа уран бүтээлээ толилуулсан.

**БНХАУ-ЫН Манжуур хотод зохион байгуулсан 13 дахь удаагийн Умардын
Олон улсын Шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн:**

Орос, Монгол, Хятад 3 улсын бус нутгийн худалдаа, аялал жуулчлал, шинжлэх ухааны салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго бүхий олон улсын Шинжлэх ухаан, технологийн 13 дахь удаагийн үзэсгэлэн нь “Прагматик –инноваци, хамтдаа хөгжих” гэсэн сэдвийн хүрээнд БНХАУ-ЫН Манжуур хотод 2016 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.



Уг үзэсгэлэнг Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам, БНХАУ-ЫН Шинжлэх ухааны академи, БНХАУ-ЫН Оюуны өмчийн газар, Шинжлэх ухаан техник мэргэжлийн танхим, Манжуур хотын Ардын засгийн ордон хамтран зохион байгуулж ажиллалаа. Тус үзэсгэлэнд Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Оюунчимэг, харьяа соёл, урлагийн байгууллагын ажилтан, албан хаагчид оролцлоо.

БНХАУ-ЫН Манжуур хотод зохион байгуулсан цас мөсний баяр, олон улсын гоо бүсгүй шалгаруулах 13 дахь удаагийн уралдаан:


БНХАУ-ЫН Манжуур хотод 2016 оны 12 дугаар сарын 22-ноос 25ны өдрүүдэд зохион байгуулсан Хятад, Орос, Монгол улсын “Цас мөсний баяр” болон олон улсын гоо бүсгүй шалгаруулах 13 дахь удаагийн уралдааны үйл ажиллагаанд тус газрын Урлагийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дэлгэрмаа Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу оролцов.

БНХАУ-ЫН Манжуур хотын захиргаанаас өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тус үйл ажиллагаанд Хятад, Монгол, Орос хөрш зэргэлдээ гурван орны төр засгийн удирдлагууд, Хэнтий, Дорнод, Орхон аймгийн Засаг дарга тэдгээрийн албаны хүмүүс уригдан бизнес аялал жуулчлалын чигэлэлээр хурал, уузалтуудад оролцлоо.

Хятад, Монгол, Орос гурван улсын Гоо бүсгүй шалгаруулах уралдаанд Монгол улсаас 15 бүсгүй оролцсоноос н.Мишээл тэргүүн байранд шалгарлаа.

Иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдал:

Байгууллагад өргөдөл гомдлын нэгдсэн программыг нэвтрүүлж, иргэд хэрэглэгчдээс гаргасан өргөдөл гомдол, хариутай албан бичигт хууль эрх зүйн



үндэслэлтэй хариуг хугацаанд нь өгч хэвшүүлсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2016 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн

зорилтод түвшин /9 хоног 23 цаг 59 мин/-д хүргэж хариуг шийдвэрлэн ажилласан.

Тус газарт 2016 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын www.ub1200.mn цахим хуудсаар өргөдөл, гомдол, санал хүсэлт нийт 20, байгууллагын 5, уулзалт 14 ирсэнийг хяналтанд авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэж ажилласан.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал:

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь 2012 оноос байгууллагын дотоод сүлжээний нууцлалтай Z://share програмыг нэвтрүүлж ажилчдын компьютерт тохиргоо хийн суулгаж өгснөөр мэргэжилтэн бүр өөрийн хийсэн ажил, хийгдэх ажлын төлөвлөгөөг байрлуулж газрын даргаар хянуулж ажиллаж байна. Үг программ нь нэгдсэн нэг сервер дээр байрладаг, гаднаас нэвтрэхийг хориглосон нууц кодтой бөгөөд ажилчдаас өөр хүн нэвтрэх боломжгүй юм.

Мэдээлэл агуулах багтаамж өндөр тул үр ашиггүй цаасны хорогдол, цаг, ажлын бүтээмж үр дүнд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан.

Мөн Мэдээллийн технологийн газартай хамтран Edoc.ub.gov.mn цахим программ хангамжийг 07 дугаар сараас эхлэн албан хаагчдад нэвтрүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн.

Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал:

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн мэдээллийн баазыг <https://ublegal.mn> Нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сан, www.ub1234.mn сайтад тогтмол шинэчилж байршуулж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Мөн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулан ажиллаж байна.

2014 оны Засгийн газрын 384 тоот тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу 2016 оны төсвийн сар, улирлын хуваарь болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төлөвлөгөө, гүйцэтгэлээр гаргаж мэдээ, мэдээллийг холбогдох маягтын дагуу цаг хугацаанд нь шилэн дансны цахим хуудас болон байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.

Ажилчин албан хаагч тус бүр дээр хөрөнгийн ашиглалтын бүртгэл нээж хөтлөн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан ажилласан.

Төсөө, санхүүгийн ил тод байдал:

2014 оны Засгийн газрын 384 тоот тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу 2016 оны төсвийн сар, улирлын хуваарь болон сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төлөвлөгөө, гүйцэтгэлээр гаргаж мэдээ, мэдээллийг холбогдох маягтын дагуу цаг хугацаанд нь шилэн дансны цахим хуудас болон байгууллагын сайтад байршуулан ажиллаж байна.

Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчтай холбогдолтой бусад хууль, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол, Нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлийн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлж, ажилласан.

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь “Нийслэлийн Засаг даргын 2012 оны Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 606 дугаар захирамжийн хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажиллаж байна. Үүнд:

- 2016 оны батлагдсан төсвийг 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, 2015 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг 2016 оны 03 сарын 25-ны өдөр, 2017 оны

төсвийн төслийг 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдөр тус тус мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэн ажилласан,

- Байгууллагын 2015 оны жилийн эцсийн тайланг 2016 оны 04 сарын 01-ний дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан,
- 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд 2016 оны 04 дүгээр сарын 01-ний дотор байрлуулан мэдээллэж мэдээллийн ил тод байдлыг хангасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай А/51 дүгээр захирамжийн дагуу зохион байгуулсан “Морин хуур” наадам, “Юби дэйнс фестиваль” чөлөөт бүжгийн наадмуудыг зохион байгуулах гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгон шалгаруулж ажиллалаа.

Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:

Тус газар нь 2016 онд батлагдсан бүтэц орон тооны дагуу 12 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж ирсэн. Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжаар батлагдсан бүтцийн дагуу тус газрын бүтэц орон тоог шинэчлэн батлаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ДӨРӨВ. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТӨВЛӨРСӨН АЖЛУУД

Нийслэлийн 377 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаанууд

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” тухай А/652 дугаар захирамж, 2016 оны “Хөрөнгө гаргах тухай” А/726 дугаар захирамжийн дагуу тус газар нь ойн хүрээнд хариуцсан төлөвлөгөөт ажлуудыг амжилттай зохион байгууллаа.

Ширээт цагаан нуурт босгосон хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслолын үйл ажиллагаа:

Монгол улсын Нийслэл хот үүсч байгуулагдсаны 377 жилийн ойн хүрээнд анхны шав тавьсан газар буюу Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Их Монгол уул, Бага Монгол уулсын дунд байрлах Ширээт цагаан нуурын хөвөөнд босгосон гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаанд 2016 оны 10 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд “Улаанбаатар” чуулгын 18 уран бүтээлчид оролцлоо. 10 дугаар сарын 21-ний орой нийслэлийн удирдлагууд,



агентлагийн дарга нарын уулзалтад дуу хуураар хөг нэмж, уулзалт амжилттай болж өндөрлөсөн.

10 сарын 22-ны 11:00 цагаас Ширээт цагаан нуурт эхэлсэн тахилгын ажилд урлагийн тоглолтын ажлыг хариуцан ажиллаж, “Ширээт цагаан нуур”-ын тахилга 17 дахь жилдээ амжилттай зохион байгуулаглаа.

Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны 24 дэх удаагийн уралдаант наадам”

Жил бүр нийслэлийн ойг угтан зохион байгуулдаг энэхүү уралдаант наадмын хүрээ өргөжиж байгаа бөгөөд энэ жилийн уралдааны нэгдүгээр шат 2016 оны 10 дугаар сарын 10-наас 13-ны хооронд дүүргүүдэд зохион байгуулагдаж 80 орчим Ерөнхий боловсролын сургуулийн 8000 гаруй сурагчид оролцсон. Төгсгөлийн шатны шалгаруулалтыг 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Монголын хүүхдийн ордонд зохион байгуулж, 18 сургуулийн 1600 гаруй хүүхэд багачууд оролцсон. Шилдэгүүдийн гала тоглолтыг 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 14 цагаас Соёлын төв өргөөнд зохион байгуулсан бөгөөд гала тоглолтод 6 дүүргийн 16 Сургуулийн 1500 орчим сурагчид оролцлоо.

Найрал дуу хэмээх урлагийн энэхүү гайхамшигт тэрлөөр дамжуулан өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд багачуудын авьяасыг нээн хөгжүүлээд зогсохгүй хүүхдүүдийг хамтын хөдөлмөр, тэсвэр тэвчээрт сургаж байдаг онцгой салбар билээ.



Энэхүү уралдаант наадмаар дамжуулан ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, хөгжмийн хичээлийн олимпиадын түвшинд зохион байгуулагдагаараа ач холбоотой.

2005 оноос Монголын Урлагийн ажилтны холбооны санаачлагаар “Хүүхдийн найрал дууны уралдаан”-ыг Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин, нэрт хормейстр Дагвын Лувсаншаравын нэрэмжит болгон зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Энэ удаагийн уралдаант наадмын Нэгдүгээр байранд Сүхбаатар дүүргийн Монгол-Оросын хамтарсан 3 дугаар дунд сургуулийн найрал дууны хамтлаг, Хоёрдугаар байранд Баянгол дүүргийн 28 дугаар сургууль, Гуравдугаар байранд Баянгол дүүргийн Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Тусгай байранд Чингэлтэй дүүргийн 50 дугаар дунд сургууль болон 39 дүгээр дунд сургуулийн найрал дууны хамтлагууд шалгарч, Шилдэг найралжууагч багшаар Шинэ Монгол сургуулийн багш Д.Амарбаяр, Шилдэг удирдаач багшаар 28 дугаар сургуулийн хөгжмийн багш С.Урантуяа, шилдэг зохион байгуулагчаар Нийслэлийн Баянгол дүүргийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн Баялагмаа нар шалгар шилдэгүүдэд шагналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд,

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаяр, Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дамдинцэрэн нар гардуулан өгсөн.

Гала тоглолтын Ерөнхий найруулагчаар Л.Ганчимэг, тайзны зураачаар А.Дөлгөөн, хөтлөгчөөр Х.Болорбат, Ц.Цэндсайхан нар ажиллаж, гала тоглолтод оролцсон сурагчдад НЗДТГ-аас бэлэг өгч, наадмын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Их хотын хямдралтай худалдааны соёл, урлагийн арга хэмжээ

Нийслэлийн 377 жилийн ойн хүрээнд 2016 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрийд Д.Сүхбаатарын талбайд Улаанбаатар хотын Захирагчийн албатай хамтран зохион байгууллаа. “Их хотын хямдралтай худалдаа” үйл ажиллагааны тайз, заслын ажлыг “Шоутек” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд 10м х 6м -ийн хэмжээтэй тайз, 4м х 6м -ийн хэмжээтэй лед дэлгэц, 24 ширхэг яригч аппаратур хөгжмийг байрлуулан, их жанжин Д.Сүхбаатарын талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэж буй иргэд, аж ахуйн нэгжид зориулан барьсан.



2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр их жанжин Сүхбаатарын талбайд Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын уран бүтээлчид тоглолтоо толилуулсан бол 2016 оны 10 дугаар сарын 29-ний өдөр “Улаанбаатар” чуулгын “Улаан театр”-ын уран бүтээлчид болон залуу авьяаслаг уран бүтээлчид өөрсдийн уран бүтээлийн дээжээсээ өргөн барьсан.

Нээлтийн үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Д.Эрдэнэсүрэн нар оролцлоо.

“Мэлхийт хөшөө” Монголын нууц товчоо”-нд хүндэтгэл үзүүлж, сүлдэт хуур цэнгүүлэх ёслолын үйл ажиллагаа

Нийслэлийн 377 жилийн ойн баярын өдрөөр Улаанбаатар хотын анхны шав тавьсан газар “Мэлхийт хөшөө”-нд хүндэтгэл үзүүлэх “Сүлдэт хуур” цэнгүүлэх ёслолыг зохион байгууллаа.

Тус үйл ажиллагаанд НИТХ-ын дарга Ц.Сандуй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Нийслэлийн Засаг даргын орлогч нар, НЗДТГ-ын дарга М.Отгонбаяр, нийслэлийн төр захиргааны



байгууллагын удирдлагууд, ажилтан, албан хаагчид оролцлоо.

Ёслолын ажиллагаанд “Улаанбаатар” чуулгын уртын дуучин МУГЖ Г.Хонгорзул, морин хуурч Г.Наранбат, “Түмэн-Эх” чуулгын уран бүтээлчид МУСГЗ Д.Цоодол зэрэг уран бүтээлчид оролцов. Уг арга хэмжээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Сандуй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд нар үг хэлж, гал голомтоо бадрааж буй шинэ хосуудад баяр хүргэж цэцэг, бэлэг дурсгалын зүйл гардуулан өгөв.

Бүтээн байгуулалтын дээд шагнал гардуулах ёслол:

Нийслэлийн 377 жилийн ойн хүрээнд их хотынхоо бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулсан байгууллагуудыг



Барилга байгууламж, Дэвшилтэт техник, технологи бүхий үйлдвэр, Франчайзинг, Брэндинг, Тусгай шагналууд зэрэг номинациудаар шилдэгүүдийг шалгаруулж, шагнал гардуулах ёслолыг 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Шангрилла зочид буудлын хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.

Тус үйл ажиллагаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Сандуй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдолын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан нар болон НИТХ тэргүүлэгчид гадаад, дотоодын зочид төлөөлөгч нар уригдан оролцсон.

Нийслэлийн бүтээн байгуулалтын дээд шагнал-2016 ёслолын ажиллагааны урлагийн тоглолтыг тус газраас хариуцаж ажилласан бөгөөд хөтөлбөрт тусгагдсаны дагуу уран бүтээлчидтэй гэрээ байгуулж, ёслолын ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулсан. Ёслолын ажиллагааны урлагийн тоглолтод УДБЭТ-ын гоцлол дуучин Э.Гомбо-Очир, УДБЭТ-ын гоцлол дуучин Б.Наранчимэг, УДБЭЧуулгын бүжигчид “Аягат бүжиг”, төгөлдөр хуурч Б.Анаар, хийлч Ч.Дэлгэрцэцэг, Шанз З хамтлаг оролцлоо.

“Аз жаргалтай хот” эсээ бичлэгийн уралдаан:

Нийслэлийн 377 жилийн ойг тохиолдуулан хотын хөгжил дэвшилд оруулах оюутан залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор “Аз жаргатай хот” эсээ бичлэгийн уралдааныг оюутнуудын дунд амжилттай зохион байгуулсан.

“Аз жаргалтай хот” эсээ бичлэгийн уралдааны шүүх шүүгчдийн хурал 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 14:00 цагт Нийслэлийн Соёл, урлагийн газрын хурлын өрөөнд зохион байгууллагдсан.

Эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулахдаа Монголын Оюутны холбоотой хамтарч их, дээд сургуулийн оюутнуудад мэдээлэл хүргэж,

удирдамжийн дагуу 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийг дуустал тус газарт биеэр болон ubculture13@gmail.com цахим хаягаар хүлээн авч ажиллалаа.

“Аз жаргалтай Улаанбаатар” эсээ бичлэгийн уралдаанд нийт 19 сургуулийн 56 оюутан эсээ бичлэгээ ирүүлсэн. Шүүгчдийн бүрэлдэхүүнд Соёл, урлагийн газрын Урлаг, уран сайхны хэлтсийн дарга М.Мөнхсайхан, НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Л.Чимгээ, Улаанбаатар хотын музейн ажилтан Г.Очбаяр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн Θ.Цэндсүрэн, нарийн бичиг НСҮГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөнтулхүүр нар ажилласан.

Их, дээд сургуулийн оюутнуудаас ирүүлсэн эсээ бичлэгтэй ажлын хэсгийн баг бүрэлдэхүүн танилцаж Нэгдүгээр байранд ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Соёл судлалын IV курсын оюутан Н.Ариумаа, Хоёрдугаар байранд Санхүү эдийн засгийн их сургуулийн бизнесийн удирдлагын I курсын оюутан Г.Түвшинжаргал, Гуравдугаар байанд Соёл, урлагийн их сургуулийн Соёлын сургуулийн менежментийн 1а ангийн оюутан Р. Энхзаяа нарын эсээг тус тус шалгаруулж, шилдэгүүдийн шагналыг Нийслэлийн 377 жилийн ойн хүндэтгэлийн концертын өмнө Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, НИТХ-ын дарга Ц.Сандуй нар гардуулж өгсөн.

Нийслэлийн 377 жилийн ойн хүндэтгэлийн хүлээн авалтын үйл ажиллагаа:

Нийслэлийн 377 жилийн ойн хүндэтгэлийн хүлээн авалттыг 2016 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 18:00 цагт Улаанбаатар зочид буудлын их танхимд зохион байгуулсан. Тус үйл ажиллагааны тайз, засал чимэглэлийг Эм Си Pi ХХК -тай гэрээ байгуулан хамтарч ажилласан. Тус үйл ажиллагаанд УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, түүний орлогчид, Монгол



Улсад суугаа элчин сайдууд, Олон Улсын байгууллагын тэргүүнүүд, Нийслэл, дүүрэг, харьяа байгууллагуудын дарга удирдлагууд, Бурхан шашинтны хийдийн Хамба лам нар уригдан оролцлоо.

Тус хүлээн авалтын үйл ажиллагаанд Нийслэлийн Улаанбаатар чуулгын морин хуурч Г.Наранбат, уртын дуучин МУГЖ Г.Хонгорзул, УДБЭТ-ын гоцлол дуучин МУСТА А.Анхбаяр, Түмэн эх чуулгын бүжигчид, Beat box Ray, Улаанбаатар чуулгын дуучин Ц.Гансүх, Хийлч Ч.Дэлгэрцэцэг, Жонон хамтлаг, “The Lemons” хамтлаг нар оролцож уран бүтээлээ толилуулсан.

Тус үйл ажиллагааг Монголын үндэсний олон нийтийн телевизийн хөтлөгч Б.Ганбаатар, Монгол телевизийн хөтлөгч С.Чимгээ нар хөтлөсөн.

Нийслэлийн 377 жилийн ойн хүндэтгэлийн концерт

Нийслэлийн 377 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн концертом мэргэжлийн урлагийн байгууллагууд УДБЭЧ, ЦДБЭЧ, ДБЭТ, Улсын филармонийн симфони оркестр, Баян Монгол чуулга, Хөгжим бүжгийн коллеж Соёл-Эрдэнэ, Өргөө хамтлаг, хөдөө орон нутгаас Сэлэнгэ, Эрдэнэт хотын уран бүтээлчид, эстрадын залуу дуучид, Монгол-Орос хамтарсан Улсын тэргүүний 3 дугаар сургуулийн сурагчид нийлсэн 500-аад уран бүтээлчдийн хамтарсан тоглолтыг Соёлын төв өргөөнд хийж гүйцэтгэлээ.

Гоцпол дуучдын
номеруудыг Улсын
Филармонийн байран дээр
хөгжимтэй 3 удаа нэгтгэн
сургуулилт хийлгэн, тайлан
дээр 10 дугаар сарын 28, 29-
нд нэгдсэн сургуулилтыг
хийсэн.

Баярын хурлын тайзны зургийг Төрийн соёрхолт зураач Болд, Sound of Mongolia компанийн дизайнер Гэрлээ нар хийж гүйцэтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаяараар батлуулан ажилласан. Концертыг МУСГЗ Д.Цоодол хөтөлсөн.



Концертыг шинэлэг хэлбэрээр хийхийн тулд Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дамдинцэрэнтэй концертын номеруудын санал солилцон залуучуудын сонирхол татсан уран бүтээл болон залуу уран бүтээлчдийг түлхүү оруулж ажиллалаа.

Мөн уран бүтээлийн чанарыг сайжруулахын тулд усан оргилуурын загварыг гаргаж батлуулан шинээр хийж гэрэл, цэцгээр чимэглэн ажилласан нь үзэгчдийн санаанд нийцсэн сайн бүтээл боллоо гэсэн үнэлгээ авсан.

Концертын номеруудтай уялдуулан шторк хийлгэн дэлгэцэн дээр гаргасан.

Концертын продюссераар Соёлын төв өргөөний захирал МУСГЗ Б.Байгалмаа, Найруулагчаар МУУГЗ Ё.Цэрэндолгор, зөвлөхөөр Төрийн хошой шагналт, МУАЖ Н.Жанцанноров нар ажиллалаа.

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМД ҮЗҮҮЛЭХ СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЧАНАРТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэл дэх соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээ түүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхээр олон ажил зохион байгуулсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг баталж цогц арга хэмжээ хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын ажлын хүрээнд нийслэлийн түүх, соёл, хөгжил дэвшилийг олон нийтэд хүргэх соёл урлагийн томоохон арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай А/51 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд доорх ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

“Дэлхийн цирк Монголд”

“Дэлхийн цирк Монголд” олон улсын циркийн тоглолтыг “Монгол циркийн хөгжлийн төв” ТББ тай хамтран 2016 оны 03 дугаар сарын 26 - 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд АСА циркд зохион байгуулж ажиллалаа. “Дэлхийн цирк Монголд” олон улсын циркийн тоглолтод 15 орны 60 гаруй жүжигчид, 45 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажилласан бөгөөд энэхүү тоглолтын үзүүлбэрүүд өмнөх жилүүдээс шинэлэг байлгахын тулд олон улсын циркийн тэмцээний шагналтуудыг урьж оролцуулснаараа онцлог байлаа.

Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр “Дэлхийн цирк Монголд” олон улсын циркийн нэг удаагийн тоглолтын билетийг худалдан авч амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхийн хүүхдүүд, халамж асрамжийн газрын хүүхдүүдэд үнэ төлбөргүйгээр үзүүлсэн бөгөөд тус үйл ажиллагаанд Сонгино хайрхан, Сүхбаатар, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй Хан-Уул дүүргүүдийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй эмзэг бүлгийн хүүхдүүд, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Дүлий иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг байгууллагуудын нийт 1923 хүүхдийг хамруулан зохион байгууллаа.




“Гэгээн Муза” театр урлагийн наадам

“Гэгээн Муза -13” театрын урлагийн наадмыг 05 дугаар сарын 15- 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Энэ удаагийн наадамд Монгол, Оросын Холбооны Улсын Буриад улс, БНХАУ-ын ӨМӨЗ орон, Польш, Грек, Герман улсуудын уран бүтээлчид зэрэг 6 орны 300 гаруй уран бүтээлчид Монголын театрын уран бүтээлүүдээрээ өрсөлдөж, авьяас билэгээ сорьж харилцан бие биенээсээ туршлага суралцаж, хамтарч наадмын үйл ажиллагаанд оролцлоо. Наадмын удирдамжийг 2016 оны 1 сард зарлаж бүртгэл 02 сарын 15-ны хүртэл явагдсан. Бүртгэлээр төв орон нутгийн болон гадны улс орнуудын нийт 34 бүтээл бүртгэгдснээс 04 сарын 01-ыг хүртэл үргэлжилсэн нэгдүгээр шатны үзлэгт хамрагдаж эдгээрээс 17 бүтээл нь “Драмын жүжгийн төрөл”, “Хөгжимт жүжгийн төрөл”, “Хүүхдийн жүжгийн төрөл”, “Нэг хүний жүжгийн төрөл”-үүдээр



хоёрдугаар шатанд өрсөлдөх эрхийг авсан. Хоёрдугаар шатны шалгаруулалтын тогтолт 2016 оны 04 дүгээр сарын 30-аас 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Театрын урлагийн шилдэг уран бүтээлчдийг шалгаруулдаг “Гэгээн Муза 13” наадмын шагнал гардуулах ёслолын ажиллагаа 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Улсын Драмын Эрдмийн Театрт болж дараах төрөлд өрсөлдөх шилдгүүдээ тодруулсан.

“Улаанбаатар бүүк фэйр - 2016” номын баяр



“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулгасан “Улаанбаатар Бүүк Фейр” номын баярыг “Номын соёлт ертөнц” төрийн бус байгууллага, Улаанбаатар Элит Олон улсын сургуультай хамтран 2016 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд зохион байгууллаа. Тус өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл нээж, Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга Б.Батцэнгэл, “Эмпати ертөнц” ХХК-ний ерөнхий захирал Карабулат Тургут, “Элит” олон улсын сургуулийн захирал Мустафа Угуз, “Номын соёлт ертөнц” ТББ-ын тэргүүн Б.Сувд, Монгол Улсын Ардын уран зохиолч П.Бадарч, Монгол Улсын Ардын уран зохиолч Т.Галсан нар байлцаж, 300 гаруй зохиолчид, 100 гаруй хэвлэн нийтлэгч байгууллагууд, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан болон бусад албаны бусад хүмүүс оролцлоо. “Улаанбаатар Бүүк Фейр” номын баяр ахмад зохиолчдодоо хүндэтгэл үзүүлэн хүндэт зочдоороо урьсан юм. Монгол зохиолчдын эвлэлийн 47, Монголын чөлөөт зохиолчдын холбооны 6 нийт 53 ахмад зохиолч хүрэлцэн ирж үншигчидтайгаа уулзсан юм. Баярын өдрүүдэд MYONTV, Ийгл телевиз, MYONRadio, TV9 телевиз шууд дамжуулж, Соён гэгээрүүлэгч, Оллоо, Стар телевизүүд тусгай нэвтрүүлэг бэлтгэж ажиллалаа. Мөн өдөр тутмын сонин, сайтын сэтгүүлчидтэй номын эрхийн бичгээр урамшуулан сурталчилгаа мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулав. Өдрийн сонин, Зууны мэдээ, Үндэсний шуудан сонин, ikon.mn, news.mn, gogo.mn, shuud.mn, unen.mn, 24tsag.mn, wikimon.mn, Mminfo.mn, Hiub.mn, garag.mn, polit.mn, mglnews.mn, Hunnu.mn, Breakingnews.mn, mongoljingoo.mn, emegteichuud.mn, everyday.mn, copy.mn, animax.mn, zone.mn, grandnews.mn, ddn.mn сайтуудаар баннер, мэдээ, мэдээлэл, сурталчилгаануудаа байршуулав. Талбайн интернетийг “Nomiin ertonts” нэрээр 2 өдрийн турш өндөр хурдтай үнэгүй цацаж иргэд,



оролцогчид цахим ертөнцөөр бие биедээ номын баярын мэдээллийг хүргэх, шууд дамжуулалт хийх боломжийг олгосон.

Тус Номын баярын үйл ажиллагааг сонирхож Жанжин Сүхбаатарын нэрэмжит талбайд цугларсан 40000 гаруй иргэдэд Нийслэлийн "Улаанбаатар" чуулга 2 өдөр шилдэг номеруудаасаа толилуулж 23 төрлийн үйл ажиллагаа, гадаад, дотоодын нийт 21 төрлийн үзэсгэлэн, номын судалгаа, сурталчилгаа, танилцуулга, 4 төрлийн тэмцээн зохион байгуулж ажиллалаа. "Улаанбаатар Бүүк Фейр" номын баярын зохион байгуулалтанд 1000 гаруй хүн оролцож ажиллалаа. Дэлхийн хамгийн алдартай Франкфурт хотын номын баярт ойролцоогоор 102 орны 7275 байгууллага, 275342 зочид, 9300 сэтгүүлч, 631 уран зохиолын агентлаг болон 170 мянга гаруй номтой холбоотой ажил эрхэлдэг хүмүүс оролцдог гэсэн тоо баримт бий. Энэ жилийн 19 дэхь удаагийн номын баяр "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсанаар олон улсын арга хэмжээ болж өргөжин дээрх жишигт нэг алхам ойртсон үйл явдал болсон байна.



"Улаанбаатар-Венийн үдэш" бүжгийн цэнгүүн

"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд "Улаанбаатар – Венийн бүжгийн цэнгүүн" үйл ажиллагааг 2016 оны 06 дугаар сарын 10-11 -ний өдрүүдэд зохион байгууллаа. "Улаанбаатар – Венийн бүжгийн цэнгүүн"-ийг 06 дугаар сарын 10-ны өдрийн 17:00 цагт Жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд тус цэнгүүнийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, Австри улсын Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, хатагтай Ирене Гинер- Райхл, Австри улсын Вена хотын их дээд сургуулийн удирдах зөвлөлийн ерөнхийлөгч Юргэн Чирновский нар нээж үг хэлэв.



"Улаанбаатар Венийн бүжгийн цэнгүүн"-д Улсын Филармоний Симфони найрал хөгжим, Нийслэлийн "Улаанбаатар" чуулгын "Хангарьд" Үндэсний найрал хөгжим, Улаанбаатар хотын Спорт бүжгийн холбоо, цэнгээнт бүжгийн "Хатан туул", "Улаан сарнай", "Moon dance" хамтлагууд, Австри улсын төгөлдөр хуурч, удирдаач Маттиас Флецбергер, хийлч Лида Баеч, балетмейстр Мартин Грунд нар хамтран оролцож Нийслэлийн иргэд, түр болон байнгын оршин суудаг гадаад



жуулчид Венийн вальс болон сонгодог хөгжмийн гайхамшигт үдшийг хамтран өнгөрүүллээ.

Тус тогтолтод нийт Монгол болон Австрийн 303 уран бүтээлч, 18 сонгодог хөгжмийн зохиол, бүтээл тоглож цэнгээнт бүжгийн үзүүлбэрийг иргэд, олон нийтэд сонирхууллаа.

Мөн 06 дугаар сарын 11-ний үдэш “Шангри-Ла” зочид буудлын “Балл” танхимд “Улаанбаатар-Венийн бүжгийн цэнгүүн”-ий тусгай зочдод зориулсан хүндэтгэлийн үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа. Энэхүү цэнгүүнээр Австрийн Элчин сайдын яамны санаачилгаар явагдсан хүмүүнлэгийн үйл ажиллагаанд зориулан хандивын аян зохион байгуулж цугларсан хандиваа Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт гардуулан өгөв.

Тус үйл ажиллагаанд Монгол улсын Филармоний найрал хөгжимчид, Улаанбаатар хотын бүжгийн Спортын холбоо, “Хатан туул” бүжгийн хамтлаг, “Улаан сарнай” бүжгийн хамтлаг, Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын үндэсний хөгжмийн “Их Монгол” хамтлаг болон амьд хөгжмийн “UFO” хамтлаг уран бүтээлээ толилууллаа.

Энэхүү цэнгүүн нь Монгол улс болон Австри улсын хамтын ажиллагаа, Улаанбаатар, Вена хотуудын найрсаг харилцааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж нийслэлчүүдээ соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нэгэн томоохон үйл ажиллагаа болж өндөрлөлөө.


“Юби дэйнс фестиваль” чөлөөт бүжгийн наадам

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд 2016 оны 06 дугаар сарын 19-ний өдө “Юби дэйнс фестиваль”, 2016 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Юби дэйнс фестиваль”-иудын гүйцэтгэгчийг Жанжин Сүхбаатарын нэрэмжит талбайд 2 дахь жилдээ олон улсын хэмжээний болгон өргөтгөн зохион байгууллаа. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу фестивалийг зохион байгуулагчийг сонгон шалгаруулсан бөгөөд “Экстрим Крейв” ХХК шалгарч, наадмыг зохион байгуулж хамтран ажиллалаа.

Фестивалийн эхний шатны шалгаруулалт 06 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын байранд зохиогдож, нийт 1500 орчим чөлөөт бүжиг сонирхогч залуучууд ирснээс ганцаарчилсан төрөлд 109 бүжигчид, хамтлаг төрөлд 26 хамтлаг өрсөлдөж ганцаарчилсан төрлөөс 32 оролцогч, хамтлаг төрлөөс 8 хамтлаг шалгарч эцсийн шатанд оролцох эрх авсан.



Бүжгийн наадмыг үзэж сонирхлоо.



Тус наадамд БНХАУ-н ӨМӨЗО, Япон, БНСУ -аас гадна Дархан, Эрдэнэт хотоос хамтлаг, бүжигчид оролцсон. Энэхүү үйл ажиллагаанд 7 төрлийн тэмцээн, бүжгийн 2 сургалт зохион байгуулсан бөгөөд бүжгийн төрөл 8 хамтлаг, ганцаарчилсан 32 оролцогч, графит зургийн төрөл 9 оролцогч орж 4000 гаруй иргэд чөлөөт бүжгийн наадмыг үзэж сонирхлоо.

Фестивалийн эцсийн шатанд хамтлаг бүжгийн төрлөөр 1 дүгээр байранд Freedom City / Эрдэнэт хот/, 2 дугаар байранд The Injust /Хан Уул дүүрэг/, 3 дугаар байранд Hooliganz crew /Баянгол дүүрэг/, 4 дүгээр байранд Up crew/ ΘМӨЗО/ хамтлаг тус тус шалгарсан. Ганцаарчилсан бүжгийн төрөлд 4 төрлөөр өрсөлдөж breakdance төрөлд Т.Хатанбаатар, Electro төрөлд Мишээл, Hip hop төрөлд Хантүшиг, Funky төрөлд Эрдэнэбилэг нар тэргүүлсэн. Мөн графитийн тэмцээнд Дашхүү, Extreme sport – оор Цогбаяр нар шалгарч наадмын шилдгүүд тодорч чөлөөт бүжиг сонирхогч залуусын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, дэлхийн чөлөөт бүжгийн аваргаас туршлага судлах боломжийг олгосон үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

“Плэй тайм - 2016” амьд хөгжмийн наадам

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан “Плей тайм” амьд хөгжмийн наадмын Ажлын хэсгийн хурлыг 2 удаа хуралдуулж зохион байгуулалтыг цаг тухай бүр хангаж ажилласан. Наадмын харуул хамгаалалт, худалдаа үйлчилгээ, тохижилт, хог хаягдал, хэв журмын болон замын хөдөлгөөний зохицуулалт, нийтийн тээврийн үйлчилгээний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжүүлэн ажилласан.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд З дахь жилдээ, “Плей тайм 2016” амьд хөгжмийн наадам олон улсын тодотголтойгоор 06 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд Гачуурт тосгоны “Монгол шилтгээн” цогцолборт 15 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

Улаанбаатар хотын иргэд, хүүхэд залуучууд болон гадаадын жуулчдад амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, тэдэнд дэлхийн болон Монголын амьд хөгжмийн шилдэг хамтлагуудыг танилцуулах зорилготой тус наадмыг нийт 6500 гаруй гадаад, дотоодын үзэгчид үзэж сонирхсон нь өмнөх оны наадамтай харьцуулахад 30 гаруй хувиар нэмэгдсэн байна.

Энэ удаагийн наадам цар хүрээгээ улам өргөжүүлж “Play time”, “Шинэ давалгаа”, “Нааглихац” гэсэн 3 тайзаар дамжуулан гадаад, дотоодын 36 хамтлагийн 217 уран бүтээлчид дэлхийн болон Монголын амьд хөгжмийн шилдэг тогтолтыг үзүүлсэн.

Гадаад орнуудаас Швед улсын алдарт “The Radio Deft” болон Японы “Roth Bart Baron”, “The You”, “Fu-Ching-Gido”, Францын “Charles Bartise”, мөн Сингапур, БНСҮ, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон, ОХУ, Финляндын 10 хамтлагийн 44 уран бүтээлч өөрсдийн уран бүтээлээ толилуулснаас гадна Монголын “Нисуванис”, “Лемонс”, “Аясын салхи”, “UFO” зэрэг 26 хамтлагийн 126 уран бүтээлч 20 гаруй DJ оролцож хотын соёл, болон амьд хөгжмийн урлагийн олон төрөл зүйлийг олон нийтэд таниулан сурталчилсан.

Наадмын уламжлал болсон “Replay market”-ийг “Made in Mongolia” уриатайгаар Монголын уран бүтээлчдийн урласан хувцас, гоёл чимэглэл, арьсан эдлэл, хөрөг зураг болон гар урлалын бүтээлүүдийг олон нийтэд дэлгэн залуу уран бүтээлчдийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Наадмын үзэгчдийн тав тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 14 байгууллагын 18 асарт халуун хоол хүнс, ус ундаагаар үйлчилсэн байна.



Наадмыг Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз, NTV, Global TV, VTV болон Гэрэг сэтгүүл сурвалжлан олон нийтэд хүргэсэн.

“Бест оф Классикс” сонгодог урлагийн үдэш

“Бест оф Классикс” сонгодог урлагийн үдшийн цэнгүүнийг “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд Улсын Дуурь бүжгийн Эрдмийн театрын өмнөх талбайд 2016 оны 07 дугаар сарын 02-ний үдэш 3 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн тоглолтод Улсын дуурь бүжгийн эрдмийн театр, улсын филармоний симфони найрал хөгжим бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, Монголын сонгодог урлагийн сор болсон уран бүтээлчид дэлхийн болон Монголын сонгодог бүтээлүүдийн дээжээс өргөн барилаа. Тус үдшийн нээлтийн үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл, Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын захирал МУСТА Ч.Мөнхзул нар нээж үг хэлэв. Тоглолтын гүйцэтгэгч байгууллагаар УДБЭТ, Саунд оф Монголия ХХК, Гэсү дизайн ХХК, Концертын продюсер МУСТА Ч.Мөнхзул, найруулагчаар МУУГЗ Е.Сарантуяа, Ерөнхий зураачаар МУСТА Г.Ганбаатар, Ерөнхий удирдаачаар МУУГЗ Н.Туулайхүү, удирдаачаар МУУГЗ Ж.Бүрэнбэх, Ерөнхий балетмейстр МУСТА Б.Жаргал, Ерөнхий хормейстр МУСТА Н.Дашбямба, Туслах найруулагчаар Б.Цэрэндаваа нар ажиллав. Энэхүү үдшийн цэнгүүнд зориулж 5000 урилга, англи, монгол хэл дээр хөтөлбөрийг суудлын план зургийн хамт хэвлэн Улсын Дуурь бүжгийн Эрдмийн театрын билетийн касс болон www.ticket.mn веб сайтаар олон нийтэд түгээв. Уг үйл ажиллагаанд “Гэсү дизайн” ХХК, “Ди лайт” ХХК, “ЛЕД” ХХК, “Саунд оф Монголия” ХХК болон Монгол наадам цогцолбор, Скай Блю Фортун ХХК нар хамтран ажиллаа. Энэхүү тоглолтыг UBS, ETB шууд дамжуулж ажиллав.



“Учиртай гурван толгой” дуурь

Монголын сонгодог урлагийн ноён оргил, үндэсний ууган бүтээл болох “Учиртай гурван толгой” дуурийг 2016 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 22:00 цагаас Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2 дахь удаагаа амжилттай зохион байгуулав.

“Учиртай гурван толгой” дуурь нь Үндэсний их баяр наадмыг угтан зохион байгуулдаг томоохон үйл ажиллагаа төдийгүй Монгол Улсын сонгодог урлагийн хөгжлийг сурталчлах, соёлын аялал жуулчлалд түүхэн ач холбогдолтой хэмээн үнэлэгдэж байна. Энэ жилийн тоглолтыг нийт 13000 орчим үзэгч үзэж сонирхсоноос 2500 гаруй гадаадын иргэд, жуулчид үзсэн байна.

"Учиртай гурван толгой" дуурийн тухай болон "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн тухай англи, монгол 2 хэлээр оруулсан бичил танилцуулга номыг 3000 хувь хэвлэж түгээсэн нь гадаад талбайд ирсэн үзэгчид, түүн дотроо гадаадын үзэгчдээс талархал хүлээлээ.

Гол дүрүүдийн сонгон шалгаруулалт

2015 онд уг дуурийг анх гадаа талбайд тоглох үед НЭДТГ-аас гол дүрүүдийг буюу Юндэн, Нансалмаа, Балган, Хоролмаа нарын дүрд тоглох дуучдыг сонгон шалгаруулж байхаар шийдвэрлэсэн юм. Сонгон шалгаруулалтыг эх орон даяар нээлттэй зарлан 06 дугаар сарын 20-ноос бүртгэж эхлэн 06 дугаар сарын 30-нд шалгаруулалтыг явуулав. УДБЭТ-ын вэб сайт, фэйсбуук хуудас болон Өдөр дутмын "Өнөөдөр", "Өдрийн сонин" -д мэдээллэж, хөдөө орон нутгийн мэргэжлийн театр, чуулгын уран бүтээлийн удирдлагуудтай утсаар холбогдож мэдээлэл хүргэсэн.



2016 оны сонгон шалгаруулалтад 16 уран бүтээлч оролцож Юндэн Э.Бумхүү /УДБЭТ/,

Нансалмаа-

Б.Энхнаран /УДБЭТ/, Балган-С.Бат-Эрдэнэ /УДБЭТ/, Хоролмаа Ө.Уянга /УДБЭТ/ нар шалгарсан. Шүүгчээр АЖ А.Дашпэлжээ, АЖ Б.Жавзандулам, УГЗ



Ж.Бүрэнбэх, УГЗ Е.Сарантуяа, мөн уг үйл ажиллагааны продюсерүүд болох НСҮГ-ын дарга Б.Батцэнгэл, УДБЭТ-ын захирал Ч.Мөнхзул нар ажилласан юм. Гол дүрийн баатруудын шагналыг 2016 оны 07 дугаар сарын 10-ны үдэш Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байранд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд гардуулан өгсөн.

"Сайланс вайт 2016" Монголын тэргүүлэх бүжгийн хэмнэл

"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд 3 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа "SILENCE WHITE" Монголын тэргүүлэгч бүжгийн үдэшлэгийг 2016 оны 07 дугаар

сарын 12-нд Үндэсний Соёл, амралтын хүрээлэнд амжилттай зохион байгуулсан бөгөөд гадаадын болон дотоодын нийт 5000 залуус хамрагдсан. Уг үйл ажиллагааны гол зорилго нь Монголын урлаг соёлыг дэлхийд түгээж, таниулах мөн дотоодын залуусыг дэлхийн электрон хөгжим, нийтийн соёл болон зөв боловсон цагийг өнгөрүүлэхэд чиглэсэн юм.

Энэ удаагийн "Silence White" Монголын тэргүүлэх бүжгийн хэмнэл үйл ажиллагааны өмнөх жилээс давуу тал болон онцлох зүйл нь шинээр гарч ирж



байгаа залуу уран бүтээлчдийг дэмжих, үндэсний хөгжмийг орчин үеийн хэмнэлтэй холбож олон нийтэд таниулахын тулд “ACEM”-ын 1800 орчим сэтгүүлч, сурвалжлагчдыг урьж оролцуулсан болно. Мөн “National News Corporation” хамтарснаар энэхүү үйл ажиллагааны талаар товч танилцуулгыг өөрсдийн сувгаар мэдээ мэдээллийг цаг тухайд хүргэж ажилласан.

“Silence White 2016” –д УДБЭТ –ын гоцлол дуучин Эрдэнэцэцэг, Уртын дууны “Өнө” чуулга, “Алтан Ураг” хамтлаг, “Radio” Entertainment –ийн залуу уран бүтээлчид, Хуурч, магтаалч Баярт, Ата Боргужин, Дуучин Mrs. M, MC Ялалт, MC Баги, Шинээр гарч буй залуу DJ нар оролцсон.

“Талын бүжиг” Монгол туургатны бүжгийн их наадам

“Талын бүжиг” монгол туургатны бүжгийн их наадмыг 2016 оны 07 дугаар сарын 12-нд Чингис хааны нэрэмжит талбайд зохион байгуулав.

Монгол үндэстэн ястны бүжгийн урлагийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг тус наадмыг “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд 3 дахь жилдээ зохион байгуулж, Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн Чуулга, Нийслэлийн “Улаанбаатар” чуулга, “Түмэн эх” чуулга, Цагдаагийн “Сүлд” чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга, Дорноговь аймгийн “Төв халхын дуулалт жүжгийн театр”, ОХУ-ны Буриад улсын “Хээрийн аялгуу” чуулга, БНХАУ-ын ӨМӨЗО –ны “Улаан мөчир” чуулга, ЦДБЭЧ-ын бүжигчид зэрэг нийт 200 гаруй уран бүтээлчид оролцлоо.



Тус наадмын гүйцэтгэгч байгууллагаар “Монголын Урлагийн ажилтны холбоо” ТББ ажиллаж, Ерөнхий найруулагчаар бүжиг дэглээч С.Сүхбаатар ТС, УГЗ, найруулагчаар Л.Батжаргал МУГЖ, туслах найруулагч Б.Баяр СТА нар ажиллалаа.

“Морин хуур” фестиваль

“Морин хуур” наадмыг 2016 оны 07 сарын 13-ны өдөр Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд зохион байгуулав.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу фестивалийг зохион байгуулагчийг сонгон шалгаруулсан бөгөөд “Арт саунд” ХХК шалгарч, наадмыг зохион байгуулж хамтран ажиллалаа.



Тус үйл ажиллагааны Ерөнхий найруулагч:

Ш.Баянмөнх, Туслах
найруулагч: Д.Бойжоо,
Тайз, шум, засал БНХАУ-
ын ажилчид, "ХАНГАРЬД"
үндэсний хөгжмийн
найрал, "Их Монгол" хамтлаг,
"Хөсөгтөн" хамтлаг, "Домог"
хамтлаг, "Жонон" хамтлаг,
"Арга билэг" хамтлаг,
"Монгол онгод" хамтлаг,
"Алтайн оргил" хамтлаг,
"Угсаатан" хамтлаг, МУ-



ын ҮДБЭЧ-ын Морин хуурын дөрвөл, Уртын дуу хамтлаг, Хөөмэй хамтлаг, Гоцпол хөгжимчид МУ-ын ҮДБЭЧ-ын гоцпол хөгжимчин О.Чулуунбаатар, НУБЧ-ын гоцпол хөгжимчин Б.Чулуунбат, СУИС-ын багш П.Мөнхжин, МУ-ын ҮДБЭЧ-ын гоцпол хөгжимчин МУГЖ.АЖ. Ч.Батсайхан, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны "Угсаатан" хамтлаг, Франц улсын иргэн морин хуур хөгжимчин, БНСУ-ын иргэн морин хуур хөгжим эхлэн сурагч, Удирдаач: Р.Ганбат зэрэг 200 гаруй уран бүтээлчид оролцлоо.

Үйл ажиллагааг 5000 гаруй иргэд үзэж сонирхосон бөгөөд Глобаль ТВ, МНС ТВ олон нийтэд шууд дамжуулан ажиллалаа.

"Свинг найт" Их талын жазз

Хотын хэмээх тодотголтой жazz урлагийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулдаг "Улаанбаатар свинг найт буюу Их талын жазз" тоглолтыг 2016 оны 07 дугаар сарын 14-ний өдөр Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд зохион байгуулав. Тоглолтод Монгол, ОХУ, Канад, Герман, Их Британи зэрэг орнуудын жazz урсгалын хамтлаг дуучид ая дуугаа өргөлөө. Энэ жилийн наадмын үеэр уригдан ирсэн БНТУ-ын нэрт жazz гитарчин, хөгжмийн зохиолч, Истанбулын алдарт "Нардис" жazz клубийг үүсгэн байгуулагч Өндэр Фожан болон түүний квартет хамтлаг өөрсдийн Турк ардын уламжлалт хөгжмөөс гадна Монголын ард түмэнд түгсэн зарим хөгжмийн бүтээлүүдийг "Стандарт А Ла Турка" жazz найруулгаар тоглосон бол ОХУ-ын шинэ үеийн мэргэжлийн жazz хөгжмийн томоохон төлөөлөгчид болох саксафонч-хөгжмийн зохиолч Павел Скорняков, төгөлдөр хуурч-хөгжмийн зохиолч Юлия Перминова, бөмбөрчин Александр Зингер, ХБНГУ-ын басс гитарчин Мартин Зинкэр нарын дөрвөл стандарт, уламжлалт жazz хөгжмийн уран сэтгэмжийг олон нийтэд толилуулсан. Токио хотоос гаралтай "Хача" хамтлаг нь Нью Орлеанс, Американо, фанки жazz төрлийн эрч хүчийг Монголын сонсогч, үзэгчдэд мэдрүүлсэн юм. Энэхүү үйл ажиллагаанд Улсын филорманийн Баян чуулга, Бүжгийн Старс хамтлаг, Пауз хамтлагаас гадна уран бүтээлчдээс дуучин Хишигээ, Улсын филорманийн Баян чуулга, дуучин Хулан, Нарка, Юри Нижимэ нартай оролцлоо. Тус наадмын гүйцэтгэгч байгууллагаар "ИХ ТАЛЫН ЖАЗЗ" ТББ ажиллалаа.



"Алдрын Од" урлагийн оддыг алдаршуулах ёслол

Монгол Улсад анхны Ардчилсан чөлөөт сонгууль болсон түүхэн үйл явдлын 26 жилийн ойг тохиолдуулан “Алдрын Од” шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн тоглолтыг 07 дугаар сарын 30 – ны өдөр зохион байгууллаа. 2015 оноос эхлэн рок, попын салбарт үнэтэй хувь нэмэр оруулж байгаа хамтлаг, дуучдыг “Алдрын од” шагналаар өргөмжлөхөөр болсон юм. Хамгийн анхны “Алдрын од” шагналыг “Соёл - Эрдэнэ” хамтлаг хүртэж байсан бол энэ жил “Харанга” хамтлаг алдрын оддын эзнээр шалгарлаа. “Соёлын төв өргөө”-ний баруун хойд талд тусгайлан бэлтгэсэн хэсэгт “Харанга” хамтлагийн одыг байрлуулсан юм. Жил бүр тус шагналыг монголын рок попын салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан шилдгүүдэд олгож, хүндэтгэлийн хэсэгт нэрийг нь мөнхлөхөөр боллоо.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд “Харанга” хамтлаг “Алдрын од” – оор шагнуулсан баярт үйл явдалд зориулж “Алдрын хүндэтгэл” рок, поп оддын тоглолтыг Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2016 оны 07 дугаар сарын 30-ны 21:00 цагаас зохион байгууллаа.

Уг тоглолтын Ерөнхий найруулагч Н.Халиун, Соёл Эрдэнэ хамтлаг, Никитон хамтлагийн дуучин Б.Батчулуун, МУГЖ Ц.Батчулуун, дуучин МУГЖ Б.Дашдондог, дуучин С.Наран, дуучин, МУСТА Т.Дэлгэрмөрөн, МУСТА Н.Наранбаатар, дуучин



Б.Баярцэцэг, дуучин А.Хишигдалай зэрэг уран бүтээлчид болон Армийн Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн хамт олон, Оргил хамтлаг, REC On хамтлагууд Харанга хамтлагийн дуунуудыг өөрсдийн хэв маяг, жанаараар Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд цугласан иргэдэд ая дуугаа өргөлөө. Үйл ажиллагааг 20000 орчим иргэд үзэж сонирхосон бөгөөд UBS телевизээр шууд дамжуулан ажиллав.

“Даншиг наадам-Хүрээ цам” шашиг, соёлын наадам

Монголын Бурханы
шашны төв Гандантэгчэнлин
хийдээс санаачлан
Нийслэлийн Иргэдийн
Төлөөлөгчдийн хурал,
Нийслэлийн Засаг даргын
Тамгын газраас дэмжиж
ажилласан “Даншиг наадам-
Хүрээ цам” шашин соёлын
наадмыг 2016 оны 08 дугаар
сарын 06, 07-ны өдрүүдэд
Хүй долоон худагт
амжилттай зохион
байгууллаа.

Нийслэлийн Засаг даргын
2016 оны 07 дугаар сарын
19-ний өдрийн “Даншиг



наадам-Хүрээ цам наадмыг зохион байгуулах тухай” А/587 дугаар захирамжийн дагуу наадам зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар тус газрын дарга Б.Батцэнгэл ажиллаж, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хуралдуулж, төсвийг нэгтгэн батлуулж, холбогдох байгууллагуудтай хамtran наадмыг зохион байгууллаа.

2016 оны 08 дугаар сарын 06-ны өдөр “Даншиг наадам –Хүрээ цам” шашин соёлын наадмыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Монголын бурхан шашиятын төв Гандантэгчэнлийн хийдийн тэргүүн их хамба лам Д.Чойжамц нар нээж, шашны зан үйлийг дэг ёсны дагуу үйлдэхэд зохион байгуулалтын хувьд дэмжлэг үзүүлэн ажиллаж,

Очирваань шүтээнийг тахих, Өндөр гэгээний дүрийг залах, Соёмбот түгийг залах, айлтгал ерөөл айлдах зэрэг шашны зан үйлүүдийг үйлдсэн юм. Энэ өдөр Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын “Colors of Mongolia” тогтолтыг наадамчин олон, жуулчдад зориулан тоглосон



2016 оны 08 дугаар сарын 07-ны өдөр “Хүрээ цам” -ыг дэг ёсоор цамнаж, ирсэн олны буян заяаг даатган цамнаж, сор залж, сүсэгтэн олонд толилуулсан.

Даншиг наадам -Хүрээ цам шашин соёлын наадмын үеэр Улаанбаатар хотноо “Зүүн хойд Азийн хотын дарга нарын форум” уулзалт зохион байгуулагдаж, үндэсний өв соёлоо сурталчлан таниулах үзүүлбэр, үзэсгэлэнг олны хүртээл болгосон.

“Уул усны домог” Монгол уран нугаралтын фестиваль

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, Урлагийн газар, Нийслэлийн “Улаанбаатар” Чуулга хамtran “Уул усны домог” уран нугаралтын наадмыг 2016 оны 08 дугаар сарын 06-ны өдөр 21 цагаас Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд амжилттай зохион байгууллаа.




“Уул усны домог” уран нугаралтын наадамд Нийслэл хотоос Үндэсний циркийн дэргэдэх Уран нугаралтын дугуйлан, шинэ цирк төвийн дэргэдэх “Отгоо” студи, Циркийн хөгжил төвийн нугараачид, Улаанбаатар чуулгын нугараачид, Эрдэнэт хотын “Эрдэнэс”, “Увидас” дугуйлан, Дархан хотын “Шонхоодой” цирк, Сэлэнгэ, Дундговь аймгаас “Сондор”, Дорноговь аймгаас “Дорнын уянга”, Ховд болон Америк улс зэрэг нийт уран нугаралтын 20 студийн 420 уран нугараач, жүжигчид ирж оролцсон.

“Монгол гайхамшиг” үзүүлбэрт тайзнаа 4 настайгаас 56 настай ахмад уран нугараачид эн зэрэгцэн нэгэн тайзнаа 420 уран нугараач нугарч Монгол гайхамшиг болсон уран нугаралтыг олон улсад сурталчилсан үйл явдал болсон юм.

Тус наадмын үеэр Нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчид уран бүтээлээ толилуулсан бөгөөд Тоглолтын ерөнхий найруулагчаар

Нийслэлийн Улаанбаатар Чуулгын дарга Р.Мөнхсайхан, “Шинэ цирк” төвийн захирал циркийн найруулагч Д.Зоригт, тоглолтын найруулагч багшаар Төрийн Соёрхолт, Ардын жүжигчин, Зууны манлай уран нугараач Б.Норовсамбуу зэрэг нийт 120 гаран баг, уран бүтээлч, ажилчид ажиллалаа.



“Ялагчдын цуваа Улаанбаатар-2016” Моно жүжгийн олон улсын наадам

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд “Ялагчдын цуваа Улаанбаатар-2016” Моно жүжгийн олон улсын наадмыг 2016 оны 08 дугаар сарын 15- наас 20 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус наадам 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Улсын Драмын Эрдмийн театрны тайзнаа болсон бөгөөд Монгол улсаас оролцож буй Улсын Драмын Эрдмийн театрны жүжигчин Ц.Баясгалан “Би Эдит Пиаф байна” жүжгээр энэхүү наадмын үйл ажиллагаа нээллээ.

Мөн наадмын өдрүүдэд Улсын хүүхэлдэйн театрын тайзнаа Польшийн жүжигчин Виүлета Комар “Дива”, Герман улсын жүжигчин Алекс Борис “Лисистрата”, Орос улсын жүжигчин Наталья Носова “Би нохой”, Тува улсын жүжигчин Галина Мунзук “Нүүр будгын өрөөнд”, жүжигчин Я.Билгүүнсар “Ашгүй бүх юм дууслаа” зэрэг моно жүжгүүд тус наадмын өдрүүдэд тоглогдож театрны урлагийн чиглэлээр суралцдаг оюутан залуус, мэргэжлийн байгууллагуудад олон улсын театр урлагийн туршлагаас судлах, суралцах боломжийг олгосон юм. Тус наадмыг зорин ирсэн гадны зочид, жуулчдаас бүрдсэн нийт 1100 гаруй үзэгчид хамрагдлаа. Ялагчдын цуваа Улаанбаатар-2016 моно жүжгийн наадмын гүйцэтгэгч байгууллагаар Монголын Моно жүжгийн төв хариуцан ажиллалаа.



“Инээмсэглэлтэй Улаанбаатар” соёлын аян

“Инээмсэглэлтэй Улаанбаатар” соёлын аяны хүрээнд Соёлын үйлчилгээг сошиал медиагаар сурталчлах төслийг Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордон, Налайх дүүргийн Соёлын ордон, Улаанбаатар хотын музейдэд хэрэгжүүлсэн. Улаанбаатар хотын музейгээс Улаанбаатар хотод заавал

үзэх 20 хөшөө дурсгалын мэдээллийг бэлтгэн олон нийтийн сүлжээгээр гаргасан. Налайх дүүргийн Соёлын ордон Инээмсэглэлтэй дүүрэг сэдвийн хүрээнд соёлын ажлууд зохион байгуулсан бол Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордон интернет сүлжээнд холбогдож, байгууллагынхаа веб сайт, фэйсбууκ хуудсыг тогтмол ажиллагаанд оруулсан. Инээмсэглэлтэй Улаанбаатар” соёлын аяны хүрээнд Глобаль телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн шторкууд, нэвтрүүлгүүдийг бэлтгэж, телевизээрээ цацах ажлыг зохион байгуулсан.

ШИНЭ ЖИЛИЙН БАЯРТ ЗОРИУЛСАН СОЁЛ, УРЛАГИЙН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх “Ажлын хэсэг байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан батлуулав.

2016 оны
12 дугаар
сарын 06-ны
өдөр
батлагдсан
“Ажлын хэсэг
байгуулах
тухай” А/852
дугаар
захирамжийн
дагуу
төлөвлөгөөний
төсөл
боловсруулан



батлуулж 2016 оны 12 дугаар сарын 13, 28, 30-ны өдрүүдэд ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдууллаа. Тус хурлаас гарсан шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” А/893 дугаар захирамж гаргуулан хэрэгжижтийг зохион байгуулж ажилласан.

2016 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Сүхбаатарын талбайд Сүлд модны гэрэл асаах ёслолыг, 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр “Улаанбаатарын мөнгөн шөнө” шинэ жилийн цэнгүүнийг амжилттай зохион байгуулсан. “Улаанбаатарын мөнгөн шөнө” шинэ жилийн цэнгүүний найруулагчаар Р.Мөнхсайхан ажилласан бөгөөд тайз засал, хөгжим аппаратурыг Эл И Ди ХХК хариуцан ажилласан. Цэнгүүнд хит болж буй дуу, хөгжим бүхий залуу уран бүтээлчид болон МУГЖ Б.Сарантуяа, МУГЖ С.Чулуунбат зэрэг уран бүтээлчид оролцож ая дуугаа өргөсөн.

БАЙГУУЛЛАГЫНХАА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА:

Нийгмийн сүлжээний Фэйсбууκ, Твиттер, Ютуб хуудсуудыг тогтмол идэвхитэй ажиллуулж байгууллагын үйл ажиллагааг шуурхай мэдээллэж, иргэд, байгууллагын санал гомдлыг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.



Тус газрын <http://nsug.ub.gov.mn> цахим хуудсаар хэрэглэгчдийн дунд үйл ажиллагааны нээлттэй байдал, хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдэллийн нээлттэй байдал, хүртээмжийн талаар улирал тутам санал асуулга явуулж оролцогчдийн 76% дэмжсэн байна. Түүнчлэн байгууллагын цахим хуудсанд давхардсан тоогоор 196022 зочин зочилж, Facebook хуудсан дээр 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6237 like, Twitter дээр 190 дагагчтайгаар үйл ажиллагаагаа иргэдэд мэдээлэлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр тогтмол үзүүлж байна.

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛУУД:

Төрийн соёрхолт, УГЗ, Чингисийн одонт, хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит мэргэжлийн дуучид, үндэсний хөгжмийн хөгжимчдийн олон улсын хоёрдугаар уралдаан:

Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Чингисийн одонт хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит мэргэжлийн дуучид, үндэсний хөгжмийн хөгжимчдийн олон улсын уралдаан 2016 оны 11 дүгээр сарын 15-наас 23-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.



Уралдааны мэргэжлийн дуучдын төрөлд БНХАУ, Казахстан улсуудын 9 оролцогч, мэргэжлийн хөгжимчин төрөлд БНХАУ-ын 2 оролцогч нийт 80 оролцогч оролцсон.

Мэргэжлийн хөгжмийн шүүгчээр: Урлагийн ажилтны холбооны хөгжмийн нийгэмлэгийн тэргүүн Н.Буянбаатар, БНХАУ-ын нэгдүгээр зэрэглэлийн хөгжимчин, профессор Су Ба Ду, МУУГЗ,

удирдаач, профессор Ч.Чинбат, Монголын Хөгжмийн зохиолчдын холбооны ерөнхийлөгч, хөгжмийн зохиолч Х.Алтангэрэл, МУСГЗ, хөгжим судлаач Ч.Буянхишиг нар, мэргэжлийн дуучдын шүүгчээр: МУГЖ, профессор, ХБК-ийн захирал Г.Эрдэнэбат, ОХУ-ын Красноярск хотын Дуурь бүжгийн театрын ерөнхий удирдаач А.П.Чебурной, МУГЖ, ХБК-ийн багш Х.Үнэнхүү, МУСТА, ДБЭТ-ын гоцлол дуучин Б.Эрдэнэтуюя, МУУГЗ, ДБЭТ-ын удирдаач Н.Туулайхүү нар ажиллалаа.

Энэхүү уралдааны ерөнхий зохион байгуулагчаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хөгжим Бүжгийн Коллеж, Шарав сан ТББ, Нийслэлийн Соёл, урлагийн газар хамтран зохион байгууллаа.

"Монгол ардын суут" /туүхэн баримтат жүжиг/

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч, суут яруу найрагч, зохиолч Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсэний 110 жилийн ойг тохиолдуулан Хүүхэлдэйн театрын тайзнаа "Монгол ардын суут" түүхэн баримтат драмын жүжгийг 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 19:35 цагт тоглосон.


Тус жүжигийн эхлэх цаг нь 19:35 цагт гэдэг нь 1935 оны үйл явдлыг харуулж буй тул нээлтээ энэхүү цаг минутад хийж үзэгч олонд сонирхуулсан. Энэ удаагийн жүжиг Хүүхэлдэйн театрт насанд хүрэгчдэд зориулсан анхны жүжиг тоглогдож байгаагаараа онцлогтой юм.



Тус жүжгийн зохиолчоор Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Ц.Хулан, ерөнхий найруулагчаар Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Б.Баатар, хөгжмийн найруулагчаар Урлагийн Гавьяат зүтгэлтэн Т.Сэр-Од, Туслах найруулагч- Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан М.Ариунтуяа, Гэрлийн техникч- Х.Камесхан, Дууны техникч- Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан Э.Базарханд, Ерөнхий зураач- В.Энх-Амгалан, Туслах зураач- Б.Бямбацэрэн, С.Энх-Од нар ажилласан юм.

“Цасангоо ба долоон одой” бүжгэн жүжиг:

Ах дүү Гриммийн зохиол “Цасан гоо ба долоон одой” сонгодог балетын тоглолтыг 2016 оны 11 дүгээр сарын 13,19-ний өдрүүдэд Корпорейт зочид буудлын концертын их танхимд “Нүүдэл балет” Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллалаа.



Тус тоглолтод зохион байгуулагчид болон бүжигчид нийтдээ 52 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг оролцсон. Тоглолтод урилгаар “Роял” балетын сургуулийн сурагчид болон “Нүүдэл балет” продакшнаас зохион байгуулж, “Номадик” уралдаанд оролцсон болон тусгай байр эзэлсэн хүүхдүүд туслах дүрүүдэд оролцон тогlossen.

Тайз засал, гэрэл, хөгжим техникийн ажлыг шинэ шийдэл бүхий лед дэлгэцээр бодит орчинг үүсгэн үзэгдэл болгон дээр хувирч засагддаг тайзыг хийснээрээ онцлогтой.

Хөгжимд дуртай залуу уран бүтээлчид:

Нийслэлийн Засаг даргын А/791 дүгээр захирамжийн дагуу “Хөгжимд дуртай залуу уран бүтээлчид” сэдэвт анхдугаар уралдааныг 2016 оны 12 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд “Дээгий мюзик” сургуульд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Уралдааны төгөлдөр хуур хөгжмийн 6-8 нас, 9-11 нас, 12-16 нас гэсэн 3 наслы ангиллаар, хийл хөгжмийн 6-9 нас, 10-16 нас гэсэн 2 наслы ангиллаар тус тус зохион байгуулсан.

Тус уралдаанд оролцогчид заавал тоглох хөгжмөөр Ц.Намсрайжав “Халуун элгэн нутаг”, Б.Дамдинсүрэн “Хэнтий өндөр ууланд” бүтээлүүдийг мөн Н.Жанцанноров “Мандухай сэцэн хатан”, Б.Шарав “Гэгээн алсад олдох юмсан”, “Баярын уянга”, “Сэтгэлийн эгшиг”, Карл Черни “Этюд №69”, “А.Николаев № 75”, Шиничи Сүзүки “Эдүди №12”, F.J. Gossec “Gavotte №17” зэрэг хөгжмүүдээс сонгон тоглож өрсөлдлөө.



Тус уралдаанд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хийл хөгжмийн төрөлд 21 сурагч, төгөлдөр хуур хөгжмийн төрөлд 224 сурагч нийт 245 хөгжим сонирхогч хүүхэд оролцлоо.

Энэхүү уралдаанд Дархан хот, Орхон, Сэлэнгэ, Сүхбаатар, Баянхонгор, Говьсүмбэр, Хэнтий, Хөвсгөл аймгуудаас ирж оролцсон нийт 43 хүүхдүүд оролцлоо.

Уралдааны шүүгчээр: Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан хийлч Ч.Дэлгэрцэцэг, Монгол улсын Боловсролын болон Соёлын тэргүүний ажилтан Хөгжим бүжгийн коллежийн төгөлдөр хуурын багш Н.Ганчимэг, Монгол улсын Гавьяат багш Л.Алтанцэцэг, Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан Соёл урлагийн Их сургуулийн хөгжимдөх урлагийн тэнхимиин багш Л.Нандинчимэг нар ажиллалаа.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙР ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ДАМДИНЦЭРЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭРГЭЖИЛТЭН  Б.МОНГӨНТҮЛХҮҮР